1.12 Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээг сайжруулах, нэмэгдүүлэхэд анхаарна.

1.13 Болзошгүй ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, иргэдийн идэвх санаачилгыг дэмжих, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулна.

1.14 Жендерийн тэгш байдлыг хангуулахад анхаарч ажиллана.

1.15 Сургууль, цэцэрлэгийн сургалтын чанар, хүртээмж, сургалтын орчныг сайжруулахад анхаарч, бодлогоор дэмжиж ажиллана.

1.16 Орчин үеийн соёл урлаг, спортын төрлүүдийг хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

1.17 Орон нутаг, алслагдсан багийн багш, эмч, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд талаар анхаарч, бодлогод тусгуулах чиглэл баримтална.

1.18 Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэх, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоог сайжруулах асуудлыг бодлогоор дэмжинэ.

1.19 Гудамж, нийтийн эзэмшлийн талбайг стандартад нийцсэн спорт тоглоомын талбай, дугуйн зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэхэд анхаарна.

1.20 Ойн санг түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах, хууль бус мод бэлтгэх нөлөөллийг таслан зогсоох замаар ойн нөөцийг хомсдолоос сэргийлэх менежментийн чадавхыг сайжруулна.

1.21 Айл өрх, албан байгууллагын хашаа, эзэмшил газар, нийтийн эзэмшлийн зам талбайг цэцэрлэгжүүлэх, арчлах, хамгаалах ажлыг нийгмийн хариуцлагын хүрээнд сурталчлан таниулна.

1.22 Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.23 Орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалыг дэмжиж ажиллана.

1.24 Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээний уялдааг хангуулна.

1.25 Нээлттэй, ухаалаг төрийн удирдлагын систем, нэгдсэн төвийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.26 Төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.

1.27 Ахмадын хөгжлийн төв, өдөр өнжүүлэх, хөгжүүлэх үйлчилгээг өргөжүүлж, гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн хариуцлагын талаар залуу гэр бүлд мэдээлэл сургалт зөвлөгөөг өргөжүүлнэ.

1.28 Төрт ёсны уламжлалт, шинэчлэлийг хослуулж, төрийн албаны ёс зүй, хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллана.

1.29 Сумын ИТХ-аас орон нутгийн ААН байгууллагуудад газар олголтыг үе шаттай шийдвэрлэж үйлдвэржилтийн бүс байгуулж зах зээлд өрсөлдөх чадвартай дэвшилтэт технологи бүхий үйлдвэр, цехүүдийг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.



- 1.30 Өрхийн тариаланчдын орлогыг нэмэгдүүлэхээр бага газраас их хэмжээний ургац авах боломжийг нэвтрүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэхээр ажиллана.
- 1.31 Түгээмэл тархацтай барилгын материалын түүхий эдийг боловсруулах шорооны карьер, тоосго зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 1.32 Сумын дэлгүүрийн хэв маяг чанар стандартыг орчин үеийн Supermarket өөрөө өөртөө үйлчлэх үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 1.33 Шинэ суурьшлын бүсийг бий болгон инженерийн шугам сүлжээнд холбох боломжийг судалж, залуу гэр бүлийн дэмжинэ.
- 1.34 Залуучуудыг сумандаа ирж ажиллаж амьдрах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжиж, хамтран ажиллана.
- 1.35 Шинээр ШТС-ын салбарыг сумандаа байгуулах ажлыг судлана.
- 1.36 Алслагдсан багуудад төрийн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ авах багийн нэгдсэн төв барих бодлогыг дэмжиж ажиллана.
- 1.37 "Хашаандаа сайхан амьдрая", "ЭКО жорлон" зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр ажиллана.
- 1.38 Шилэн кабель, Unitel сүлжээ орсонтой холбоотой Univision холбогдох ажлыг судалж, холбох ажлыг эхлүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 1.39 Сумын ард иргэдээс үүрэн холбооны сүлжээ муу газруудын талаар судалгаа гарган, сайжруулан антен тавиулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлэхээр ажиллана.
- 1.40 Орон нутгийн чанартай авто замууд, Эрдэнэт хот болон Сэлэнгэ сумын хоорондох авто замыг хэсэгчлэн чанар стандартад нийцүүлж өргөтгөх, ус зайлуулах хоолой, тэмдэг тэмдэглэгээ, явган хүний гарц болгох талаар аймаг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т асуудал тавьж, шийдвэрлүүлэхээр ажиллана.

Мэдээллийг бэлтгэсэн:
Бие даан нэр дэвшигч



/В.Баттулга/

ТХ 88011713

99011891



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 383

танай _____ -ны № _____ т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Бие даан нэр дэвшигч Л.Оюун-отгоны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа 2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Л.Оюун-Отгоны Сэлэнгэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Л.Оюун-Отгоны мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

006020604

Хувийг:Сэлэнгэ сумын сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



**БУЛГАН АЙМГИЙН СЭЛЭНГЭ СУМЫН 2020 ОНЫ СУМЫН ИТХ-ЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЛХАГВА ОВОГТОЙ,
ОЮУН-ОТГОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Сэлэнгэ сумынхаа нийт иргэн бүрийн төлөө шударга, ёс зүйтэй дуугарч үгээ хэлж, үйлдлээрээ харуулах нэр дэвшигч байж "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад уялдуулан сумандаа хийх хүсэлтэй байгаа ажлуудаа мөрийн хөтөлбөртөө тусгалаа.

1. Сумын бодлогын баримт бичиг, өнөөгийн нөхцөл, цаашдын хандлага, бэлчээр ашиглалт, хүн амын суурьшилтай уялдуулан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах чиглэл баримтална.
2. Сумын газар зүйн онцлог, байгалийн нөөц, дэд бүтцэд нийцсэн хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, анхаарч ажиллана.
3. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг тэдгээрийн эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагуудаар дамжуулан сумын бодлого, шийдвэрт тусгана.
4. Сумын төвийн тохижилтыг үргэлжлүүлэн сайжруулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, иргэдийн ажиллаж, амьдрах тавтай орчныг бүрдүүлэхэд анхаарч, бодлогоор дэмжинэ.
5. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай зорчигч тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
6. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, эх үүсвэрээр хангах, утаагүй түлш үйлдвэрлэх ажлуудыг дэмжиж ажиллана.
7. Сумын төв, багийн төвүүд, нийтийн эзэмшлийн талбай, олон нийтийн газарт интернэт холбогдох WIFI орчныг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.
8. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур иргэд болон бага малтай залуу малчин өрхийг дэмжинэ.
9. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого барьж, орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжиж, дотоод зах зээлээ хамгаалах бодлогоор дэмжинэ.
10. Байгаль орчныг хамгаалах, нийтийн эзэмшлийн талбайг засаж тохижуулах зэрэг нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөнөөр хамруулна.
11. ХАА-н биржийн арилжааг идэвхжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

Бие даан нэр дэвшигч

Л. Оюун-Отгон

/Л.Оюун-Отгон/



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 384

танай _____-ны № _____ т

СЭЛЭНГЭ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Б.МӨНХТҮВШИН ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Бие даан нэр дэвшигч Б.Мөнхтүвшиний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа 2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Б.Мөнхтүвшиний Сэлэнгэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Б.Мөнхтүвшиний мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

006020606

Хувийг:Сэлэнгэ сумын сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай


ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

**БУЛГАН АЙМГИЙН СЭЛЭНГЭ СУМЫН 2020 ОНЫ СУМЫН ИТХ-ЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БАЯРАА ОВОГТОЙ
МӨНХТҮВШИНГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



2020 оны 07 дугаар сарын 24

Монгол Улс Ардчилсан хувьсгал гарснаас хойш монгол улсын иргэн өөрийн сонголтоо чөлөөтэй хийх болсон. Улс төрийн 8 дахь удаагийн сонгууль, 28 жилийн хугацаанд 7 удаа хийж сонгуулиас сонгуулийн хооронд төрийн нэр хүндийг унгаж иргэдийн төрд итгэх итгэлийг алдсаар өнөөдрийн түвшинд хүрлээ. Иргэдийн аж ахуй доогуур амьжиргаа бага мэдээ мэдээлэл дутмаг, залуучуудын оролцоо бага байгаа ба үүнийг өөрчлөхийн тулд бие даан өрсөлдөж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад нийцүүлэн мөрийн хөтөлбөрөө боловсрууллаа. СУМАА ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Зорилго: Иргэдийнхээ эрх ашгийг дээдлэн, хувь хүн өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялаг бүтээгчдээ дэмжин, шинэ технологи нэвтрүүлж, үйлдвэрлэлийг хөгжүүлсэн сум болоход оршино.

1. ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 1.1 Сумын Багуудийн газар зүйн онцлог, дэд бүтэц зэрэгт нийцүүлэн сүү цагаан идээ, жимс жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулах жижиг дунд үйлдвэрлэлийг баг бүрт бий болгож, Орхон аймагт худалдаалах сувгийг бий болгож ажиллана.
- 1.2 Махны чиглэлийн аж ахуй болон мал бордох, мах боловсруулах үйлдвэр байгууллахыг дэмжинэ.
- 1.3 Сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэхэд дэмжиж ажиллана.
- 1.4 Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхрийг үндсэн сайжруулагчаар ашиглаж, ашиг шимийг нэмэгдүүлэхэд дэмжиж ажиллана.
- 1.5 Хонин сүрэгт Баяд, Хангай, Дархад, Хотонд омгийг, ямаан сүрэгт Эрчмийн хар, Баяндэлгэрийн улаан омгийг тус тус үндсэн сайжруулагчаар ашиглан баг бүрийг хээлтүүлэгч малаар хангах тал дээр дэмжинэ.
- 1.6 Бэлчээрийн менежментийг сайжруулах тусгай төлөвлөгөө гарган ажиллана.

- 1.7 Малчин тариаланчдийн харилцааг зохиоцуулах журмыг боловсруулна.
- 1.8 Малын хоёр дахь түүхий идээр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нь дэмжинэ.
- 1.9 Газар тариалангийн зориулалтай ашиглаж байгаа газруудад хэмжилт хийхэд анхаарч ажиллана.

2. ДЭД БҮТЭЦ

- 2.1 Суманд орчин үеийн технологи, шийдэл бүхий үйлчилгээний газрыг байгуулахыг дэмжинэ.
- 2.2 Сумын төвд халуун усны газар шинээр барихад тал дээр анхаарч ажиллана.
- 2.3 Бүрэн дунд сургуулийн их засвар хийхэд шаардагдах хөрөнгийн шийдвэрлэхэд дэмжиж ажиллана.
- 2.4 Сумын төвийн тохижилтыг үргэлжлүүлэн сайжруулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, иргэдийн ажиллаж, амьдрах тавтай орчныг бүрдүүлэхэд анхаарч, бодлогоор дэмжинэ.
- 2.5 Сумын төвийн камержуулахад дэмжинэ.
- 2.6 Сэлэнгэ сумаас Орхон аймаг орох замын трансг өөрчлөж Хар модын даваагаар шинээр зам тавихад дэмжиж ажиллана.
- 2.7 Сумын төвийн интэрнетын хурдыг сайжруулан нэмэгдүүлэхэд чиглэж ажиллана.

3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ


- 3.1 Барилagyг материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 3.2 Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бодлого гаргаж ажиллана.
- 3.3 Сум хөгжүүлэх сангийн чанарыг сайжруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 3.4 Нөхөрлөлийн үйл ажиллагааг сайжруулна.
- 3.5 Мод бэлтгэлийн мэргэжлийн байгууллага байгуулан ажиллахыг дэмжинэ.

4. ЭРДЭМ БОЛОВСРОЛ

- 4.1 Шатар, морин хуур, бие биелэгээг хөгжүүлэхэд анхаарч ажиллах.
- 4.2 Насан туршийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд иргэдэд боловсрол олгоно.
- 4.3 Орон нутгийн түүх, соёлын музейг бий болгоход дэмжинэ.
- 4.4 Багшийн хөгжлийг дэмжиж ажиллана.
- 4.5 Уламжлалт "үндэсний сур" "шагайн харваа"г хөгжүүлнэ.

5. ЭРҮҮЛ МЭНД

- 5.1 Нийгмийн эрүүл мэндийг дэмжинэ.
- 5.2 Улирал бүрийн онцлогт тохирсон нийтийн уралдааныг зохион байгуулна.
- 5.3 Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэхэд түлхүү анхаарна.
- 5.4 Нийгмийн эрүүл мэндийг дэмжиж шинэ шатанд гаргана.
- 5.5 Урдчилан сэргийлэх сургалт суртчилагааг сайжруулж ард иргэдийг эрүүл амьдрах зөв дадалыг эзэмшүүлэхэд дэмжиж ажиллана.
- 5.6 Эрүүл мэндийг дэмжсэн үйл ажиллагаанд бүх байгууллага нийт иргэд хамрагдах тал дээр анхаарч ажиллана.



6. ТӨРИЙН УДИРДЛАГА

- 6.1 Орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалыг дэмжиж ажиллана.
- 6.2 Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээний уялдааг хангуулна.
- 6.3 Нээлттэй, ухаалаг төрийн удирдлагын систем, нэгдсэн төвийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 6.4 Төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.
- 6.5 Ахмадын хөгжлийн төв, өдөр өнжүүлэх, хөгжүүлэх үйлчилгээг өргөжүүлж, гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн хариуцлагын талаар залуу гэр бүлд мэдээлэл сургалт зөвлөгөөг өргөжүүлнэ.
- 6.6 Төрт ёсны уламжлалт, шинэчлэлийг хослуулж, төрийн албаны ёс зүй, хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллана.
- 6.7 Төрийн албан хаагч нарт ажлын гүйцэтгэлийн үнэлгээний системийг нэвтэрүүлнэ.

МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭСЭН БИЕ
ДААН НЭР ДЭВШИГЧ

Б.МӨНХТҮВШИН

81186071813
99966614



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 386.

танай _____-ны № _____ т

Баяннуур сумын иргэдийн
төлөөлөгчдийн хурлын сонгуульд
оролцох бие даан нэр дэвшигч
Л.ОДОНЧИМЭГ ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баяннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Л.Одончимэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Баяннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа 2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Л.Одончимэгийн Баяннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

006000612

Бие даан нэр дэвшигч Л.Одончимэгийн мөрийн хөтөлбөр хуудсыг хавсаргав.

Хувийг:Баяннуур сумын сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай


ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЛХАГВА ОВОГТОЙ
ОДОНЧИМЭГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Мөрийн хөтөлбөрийн үндсэн зорилго нь : Аймаг сумын дэд бүтэц, газар тариалан, ашигт малтмалын нөөц зэрэг давуу талуудад тулгуурлан, эдийн засгийн чадавхыг өсгөх бизнесийн орчныг дэмжсэнээр орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг сайжруулан, хүний хөгжлийг дэмжиж ажиллахад оршино.

Би "Хөгжлийн төлөө хамтдаа" гэсэн уриаг дэвшүүлж, аймаг, сумын хөгжил, ард иргэдийн ирээдүйдээ итгэлтэй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг иргэдийн санал хүсэлт дээр үндэслэн боловсруулсан.

Зорилт : Орон нутгийн хуралд иргэний төлөөллийг нэмэгдүүлснээр иргэдийн санал бодлыг бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд шууд хүргэж, ИТХ-аас гарч буй бодлого шийдвэрийг намын тал цал намчирхлаас ангид, иргэдэд нээлттэй тэдний оролцоотой гаргаж, аймаг сумаа хөгжүүлэхэд оршино.

Мөрийн хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэх ба орон нутгийн иргэдийн эрх ашгийг нэн түрүүнд тавих тэднийг амжилтад хүргэх, ашиг орлогоо дээшлүүлэхэд чиглэсэн бодит ажлуудыг санал болгож байна.

1. Хэт улс төржилт, намуудын тал цал, засаглалын хямралаас зайлсхийж, иргэдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөллийн ардчиллын тэгш зарчмыг баримтлан ажиллана.
2. Баяннуур сумын бизнес, эдийн засгийн хөгжлийн гарцыг тодорхойлох, орон нутгийн хөгжлийн урт хугацааны бодлого төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг иргэдийн саналыг үндэслэн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
3. Ингэснээр орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх жижиг болон дунд бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
4. Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан болон бусад сангийн хөрөнгийн зарцуулалтыг нээлттэй болгож, иргэдийн санал санаачилга дээр тулгуурлан суманд тодорхой бизнес үйлдвэрлэл, ажлын байр бий болгоход чиглүүлнэ.
5. Төсөв, мөнгө, боловсон хүчний болон эд хөрөнгийн эрх мэдлийг бодитой шилжүүлэх хэрэгжүүлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлнэ.
6. Орон нутагт зарим атаршсан газар нутгуудын нөхөн сэргээлтийг эрчимжүүлж ашиг өгөх мод бут сөөг, хүнсний ногоо, ногоон тэжээл, эмийн ургамал тариалах зэргээр эргэлтэд оруулах бодлого хэрэгжүүлнэ.
7. Мөн хадлангийн талбайн ашиглах, сэргээх га-аас авах ургацыг нэмэгдүүлэх, өвс тэжээлийн хадгалалт хамгаалалт борлуулалт, хадланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд аймаг сум орон нутгийн засаг захиргаа болон, хадланчид, ТББ-уудтай хамтран тодорхой бодлого шийдвэр гаргуулж хэрэгжүүлж ажиллана.
8. Аймаг сумын бэлчээрийн даац хэтрэлт, нутгийн иргэдийн өвөлжөө хаваржаа бэлчээрийг хамгаалах, малын тоо толгойн зохист харьцааг барих чиглэлээр отрын бүс нутгийн захиргаа тухайн аймаг сумдын хурал захиргааны байгууллагуудтай хамтран дүрэм журам боловсруулан хэрэгжүүлэх ажлыг хянаж мөрдүүлж ажиллахад анхаарна.

9. “Эрүүл мал- эрүүл хүнс” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аймаг сумандаа орон нутгийн малын үүлдэрлэг байдлыг сайжруулахад анхаарч адууны угшлыг сайжруулах, мах сүү ноос ноолуурын чиглэлийн үхэр хонины ямааны суурь үүсгэх зэргээр ажиллана. Мөн мал эмнэлгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг зорьж ажиллана.
10. Аялал жуулчлалын бодлого боловсруулж, байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах замаар эко аялал жуулчлалыг хөгжүүлж үүгээр дамжуулан малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх орон нутгийн соёлын түүхт дурсгалт газруудыг зохистойгоор сурталчлан таниулж, хадгалан, хамгаалан авч үлдэхэд анхаарч “Аялал жуулчлалын цогц бодлого” батлуулж ажиллана.
11. Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, мэрэгч амьтантай тэмцэх замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ. Бэлчээрийн даац, төлөв байдлын судалгаанд тулгуурлан эдийн засгийн оновчтой хөшүүргийг ашиглан малын тоо, төрөл, сүргийн зохистой бүтцийг тогтоох, ашиглагдахгүй байгаа бэлчээрт худаг гаргах замаар бэлчээр усжуулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарна.
12. Сумын бизнес төлөвлөгөө боловсруулж, орон нутгийг аж ахуйн аргаар хөгжүүлэх, гахай тахиа жимс ногооны, өрхийн хоршоолол аж ахуй иргэдийг дэмжиж, эцсийн бүтээгдэхүүн гаргах зах зээлд нийлүүлэх боломжийг судална.
13. Цөлжилттэй тэмцэх орон нутгийг ойжуулах чиглэлээр модны төрөл зүйлийг нэмэгдүүлэх, услалтын системийг боловсронгуй болгох, модны амьдралын хувийг нэмэгдүүлэх, гол нуур, мод бут сөөгийг хамгаалах чиглэлээр байгаль орчныг хамгаалах бодлого боловсруулан уламжилж ажиллана. Мөн мод бут суулгац тариалж буй иргэд аж ахуй нэгжийг зах зээлд дэмжих ажлыг эхлүүлнэ.
14. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх боломжтой ажлуудын судалгааг гаргаж төсөвт суулгахад анхаарч аймгийн ИТХ-ын хуралдаанаар санал оруулж ажиллана.
15. Гадаад дотоодын болон олон улсын хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрийг орон нутагтаа татан төвлөрүүлэх ажлыг аймаг сум орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулна.

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Өндөр настны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдах, эмийн нөөцийг нэмэгдүүлэх, тэдний чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж бололцоог хангах нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого боловсруулж ажиллана.
2. Залуу гэр бүлийг дэмжих зорилгоор бага өртөгтэй орон сууцыг барьж орон сууцжуулах, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжийг судална.
3. Малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, мал мах гадаад дотоод зах зээлд гаргах арьс шир түүхий эд, сүү цагаан идээг боловсруулах үйлдвэрийг бүсчлэн байгуулахад аймгийн ИТХ -д өөрийн санал санаачилгыг гаргана.
4. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжиж, орон нутагтаа үйлдвэрлэл эрхлэх гарааны бизнес эрхлэх боломжийг бий болгож бизнес эрхлэгч нарыг бодлогын түвшинд дэмжин ажиллана.
5. Амьдралын түвшин доогуур орлоготой болон, өрхийн орлого бага иргэдэд малжуулах гэргүүлэх хөтөлбөрийг нэмэгдүүлэх ядуурлыг бууруулахад чиглэгдсэн гадаад,